



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/33

Дэлгэрмөрөн

**Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөнийг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ерөнхийлөгчийн 58, 63 дугаар тоот зарлиг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.4, 5.1.6, 5.1.8, 5.1.9, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.1.1, 6.1.2, 6.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Улсын хэмжээнд “Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөн”, бүх нийтээр мод тарих үйл ажиллагааг сумын хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ний өдөр, 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Хөтөлбөрийн хүрээнд мод, сөөг тарих хүсэлтэй иргэд байгууллагын судалгааг гаргаж, захиалгыг авч, ажлын хуваарь гарган, үр дүнг тооцож, хяналт тавих, зөвлөн туслах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч: С.Нархүү (Засаг Даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Б.Ууганбаяр (Дэлгэрбаян дунд сургуулийн захирал)

Я.Оюунчимэг (Дэгдээхэй цэцэрлэгийн эрхлэгч)

М.Дорждагва (Эрүүл мэндийн төвийн дарга)

С.Батхолбоо(Соёлын төвийн эрхлэгч)

Ч.Хүчитбаатар (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э.Эрэвгийлхам (Хамба лам)

Ю.Батмөнх (Хөх бүрд 1 дүгээр багийн Засаг дарга)

С.Төмөрбаатар (Соноор 2 дугаар багийн Засаг дарга)

П.Түвшинтөгс (Норовлин 3 дугаар багийн Засаг дарга)

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201065

Б.Батшагай (Цорж 4 дүгээр багийн Засаг дарга)

С.Очирбат (Дэлгэрмөрөн 5 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Даваасүрэн (Байгаль хамгаалагч)

3.Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн эзэмшил талбайн ногоон байгууламжийг сайжруулах, ногоон байгууламж бий болгох, сумын Засаг даргын Тамгын газраас хуваарилж өгсөн талбайд нүх ухаж, мод, сөөг тарьж, ургуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн захирал, байгууллагын дарга, эрхлэгч нарт

4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтан, албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мод тарьж ургуулах нөхцөл боломжоор хангаж, талбайг хуваарилах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг байгаль орчны алба, айл өрхийг хашаандаа 5-аас доошгүй мод, сөөг тарьж ургуулах ажилд багийн иргэдийг идэвхтэй оролцуулахыг багийн Засаг дарга нарт

5.Ажлын явц, үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Байгаль хамгаалагч, Байгаль орчны мэргэжилтэн нарт

6.“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болон Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөний үр дүн, тайланг гэрэл зургийн хамт хагас, бүтэн жилээр Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА  С.СУМЬЯАБАЗАР